

**ГЭР БҮЛИЙН ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ**



Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 54 дүгээр тогтоолын хавсралт

ГЭР БҮЛИЙН ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 01/1249 дугаар албан бичгээр санал авахаар ирүүлсэн Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл (2025.09.15-ны өдрийн байдлаар)-ийг Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.3-т заасны дагуу хэлэлцэв.

Монгол Улсад анх удаа Гэр бүл, хүүхдийн хэргийн дагнасан шүүх байгуулахаар тогтож тус шүүхээр хянан шийдвэрлэх хэргийн харьяаллыг тогтоож, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тусгайлсан зохицуулалтыг бий болгох шаардлага зүй ёсоор үүсэж байна. Төсөлд зарчмын болон агуулгын шинжтэй дараах санал байна.

1. Гэр бүл, хүүхдийн хэргийн шүүхийг дагнан байгуулсан хөгжингүй зарим оронд гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэж буй "Эдгэрүүлэх зүй ёс" /Therapeutic justice/-ны зарчим анхаарал татаж байна. Гэрлэлт дуусгавар болохтой зэрэгцэн эхнэр, нөхөр, хүүхдийн сэтгэл зүйн эрүүл мэндийг анхааран, гэр бүлд тулгарсан хүндрэлийг даван туулж, тогтвортой, эрүүл харилцаа тогтоохыг эрмэлзэх, хүүхдэд тавих бүх талын анхаарал халамж, асрамжийг зөв зохистой байлгахад дэмжлэг үзүүлэх зорилготой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эдгэрүүлэх зүй ёсны зарчимд нийцсэн гэж үзэх бөгөөд хуулийн төсөл энэ үзэл баримтлалыг дэмжсэн байвал зохино. Гэр бүл, хүүхдийн хэргийн шүүх нь энэ зарчмын хүрээнд үйл ажиллагаа явуулахын тулд бүтэц, зохион байгуулалтын ихээхэн онцлогтой байхыг анхаарч хуулийн төслийг боловсруулан, цаашид авах арга хэмжээг төлөвлөх шаардлагатай байна.

2. Хуулийн төсөлд тус шүүхийн харьяалан шийдвэрлэх хэргийн хүрээг зөв тогтоох шаардлагатай. Ингэхдээ гэр бүлийн харилцааны материаллаг хэм хэмжээ болох Гэр бүлийн тухай хуульдаа үндэслэсэн байвал зохино. Нийгмийн харилцааг процессжуулсан аливаа хэм хэмжээ нь тодруулбал, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа нь өөр өөрийн материаллаг хуульд тулгуурлан системчлэгдсэн бөгөөд ингэснээр хэргийн ба шүүхийн харьяаллын алдаа гарахгүй, процессын зохицуулалтгүй материаллаг харилцаа үлдэж, эрх зүйн хийдэл бий болохгүй байх үндэс бүрдэх юм.

Иймд Гэр бүл, хүүхдийн хэргийн шүүхийн харьяалан шийдвэрлэвэл зохих иргэний хэргийг гэр бүлийн хүчин төгөлдөр мөрдөж буй хуулийн системчлэлийн дагуу тогтоох зүй тогтлыг баримталбал зохино. Ингэснээр гэр бүлийн шинжтэй



иргэний хэрэгт гэрлэлтийн харилцаанаас үүсэх; гэр бүлийн эд хөрөнгийн харилцаанаас үүсэх; эцэг, эх хүүхдийн харилцаа; тэжээн тэтгэх, тэтгүүлэхтэй холбогдсон харилцаа; үрчлэлтийн харилцаа; асрамжийн харилцаа; асран хамгаалах, харгалзан дэмжих харилцаанаас үүсэх маргаанууд эн тэргүүнд хамаарах юм. Түүнчлэн гэр бүлийн эрх зүйн хөгжлийн ирээдүйн чиг хандлагыг харгалзан тээгч эх, гэрлэлтийн гэрээ зэрэг шинэ тутам харилцаанаас маргаан гарч болохыг анхаарч гэр бүлийн холбогдолтой бусад хэрэг гэх байдлаар томъёолох нь зүйтэй.

3.Онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэгдэх зарим хэргүүд гэр бүлийн хэргийн шинжийг шууд агуулахгүй ч садан төрлийн болон тус харилцаанд оролцогчдын хувийн хамааралд суурилах байдлаараа гэр бүлийн хэргийн шүүхийн харьяалах маргаанд тооцогдож байна. Харин эдгээр маргааныг төсөлд тусгахдаа "Нэхэмжлэл, хүсэлт гаргах харьяалал" гэж нэрлэсэн нь иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйд "нэхэмжлэлийн харьяалал" гэх онолын бус шинэ ухагдахуун бий болгон "шүүхийн харьяалал", "хэргийн харьяалал" гэх үндсэн ойлголтын тогтсон хэрэглээг хөндөх сөрөг талтай байна.

Түүнчлэн онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэгдэх зарим хэргийн хувьд харьяаллыг тодорхойлохоос өмнө шүүхийн практикийг судлах шаардлагатай. Тодруулбал, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 135 дугаар зүйлийн 135.2.3-т төрөлт, үрчлэлт, гэрлэлт, гэрлэлт цуцлалт, нас баралтыг бүртгүүлсэн байдлын талаарх хэргийг эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдал гэж үзэн онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэхээр заасан. Гэвч хуулийн төсөлд тус маргааныг ердийн харьяаллын шүүх хянан шийдвэрлэхээр үлдээсэн шалтгаан тодорхойгүй байна.

4.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлтэй зэрэгцүүлэн Засгийн газраас Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг өргөн барихаар боловсруулсан байна. Төслийн 21 дүгээр зүйлд хамтран амьдрагчдын харилцааг зохицуулан объектив шалгуурыг тогтоосноос үзвэл тус харилцааг Гэр бүлийн тухай хуулийн зохицуулах зүйл гэж үзжээ. Хэрэв тус хуулийн төслүүд цаг хугацааны хувьд зэрэгцэн батлагдах бол Гэр бүлийн тухай хуулийн агуулга Гэр бүлийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль дахь хэргийн харьяаллыг тогтооход ихээхэн нөлөөтэйг анхаарвал зохино.

5.Гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны шүүх нотлох, талууд тэгш мэтгэлцэх зарчмаас гадна хүүхдийн ашиг сонирхлыг дээдлэх зарчим; хүүхдийн эрх ашиг хөндөгдсөн, хүчирхийллээс үүссэн хэрэг маргааныг шуурхай шийдвэрлэх зарчим; хэргийн оролцогчийн, тэр дундаа нас үл харгалзан хүүхдийн байр суурийг заавал сонсох зарчим; эвлэрлийг дэмжих зарчим; хууль зүйн мэргэжлийн төлөөллийн зарчим; ил тод байдал ба хувийн нууцын тэнцвэрт байдлыг хадгалах зарчим; урьдчилсан арга хэмжээ авах зарчмууд үйлчлэх онцлогтой.

Төсөлд шүүх өөрөө нотлох, мэтгэлцэх, хүүхдийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримтлах талаар томъёолохдоо эдгээрийг нэр дурдан жагсаах хууль зүйн техникийг ашигласан нь оновчтой болсонгүй. Энэ нь хууль хэрэглээний



тодорхойгүй байдлыг бий болгох сөрөг талтай тул зарчмыг нэрлэн жагсаах бус, шүүх нотлох процесс үйлчлэх тухайн ажиллагаа, арга хэмжээнд шүүхийн оролцоог хангасан байдлаар томьёолж, бусад тохиолдолд мэтгэлцэх зарчим үйлчлэх, хүүхдийн эрх ашгийг дээдлэх зарчмын агуулгыг илэрхийлэх замаар төслийг боловсруулах нь эрх зүй тодорхой байх зарчимд нийцнэ. Гэрлэгчдийн хооронд эд хөрөнгийн маргаан өрнөж буй үед шүүх нотлох зарчмыг баримтлах нь зохимжгүйн нэгэн адил хүүхдийн эрх ашиг хөндөгдсөн, хүчирхийллийн үр дагавартай холбоотой харилцаанд дан ганц талууд тэгш мэтгэлцэх зарчмыг баримталж ажиллагаа явуулах боломжгүй.

Иймд зарчмуудыг нэрлэн жагсаах замаар бус, харин зарчим тус бүрийн агуулгыг тодотгон, шүүхийн оролцоо шаардлагатай тухайн тодорхой хэсэгт шүүх санаачилгаараа ажиллагаа хийж болохыг заан томьёолох нь оновчтой. Өмнө дурдсанчлан гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хүүхдийн хууль ёсны эрх ашгийг дээдлэх буюу хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалах зарчим эн тэргүүнд үйлчилдгээрээ онцлог. Зарим улс орнууд энэ зарчмын дор гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоогүй ч хүүхдийн эрх ашгийн үүднээс гуравдагч этгээд буюу хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр мэргэшсэн байгууллагууд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гомдол гаргах, шүүхийн шийдвэрт давж заалдах, хяналтын шатны журмаар гомдол гаргах боломж олгосон байдаг.

6. Гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа нээлттэй, эсхүл хаалттай байх эсэх нь тус шүүхийн харьяалан шийдвэрлэх маргааны төрөл, агуулгаас хамаарах юм. Хуулийн төслийн үйлчлэлд хамаарах гэр бүлийн холбогдолтой бүх хэргийг хаалттай байхаар зохицуулах нь зохимжгүй. Зарчмын хувьд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нээлттэй явагдах бөгөөд харин Монгол Улсын шүүхийн тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэлээр гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хаалттай явагдаж болно.

Дээрх хоёр хуулийн үйлчлэлд хамаарахгүй боловч хаалттай явагдах шаардлагатай хэрэг маргаан байж болохыг ч үгүйсгэхгүй тул хэргийн оролцогчийн хүсэлтээр, шүүхийн санаачилгаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хаалттай явуулахаар томьёолох боломжийг судлах нь зүйтэй.

Түүнчлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хаалттай байх, гагцхүү шүүх хуралдаан хаалттай байх, эсхүл шүүх хуралдаан нээлттэй байж болох ч цахимаар нэвтрүүлэхгүй байх ялгамжтай хувилбарыг харгалзан уян хатан зохицуулалтыг томьёолж болох юм.

7. Зохигч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөллөөр бус өөрөө оролцох явдлыг үүрэгжүүлсэн төслийн үзэл санааг дэмжиж байна. Улмаар энэ үүргээ хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хэрэгжүүлээгүй бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байгаа шүүгч өөрөө хариуцлага тооцох боломжийг хуульчлах нь чухал байна. Гэрлэлтийн маргаан шийдвэрлэж байх үед өөрөө оролцохгүй байх, гэр бүл цуцлах асуудлыг төлөөллөөр дамжуулан шийдвэрлэх нь гэрлэлт цуцлахаас гадна хүүхдийн асрамж, тэтгэлгийн талаар тохиролцох,



хүүхдэдээ анхаарал халамж тавих үүргээ биелүүлээгүйн үр дагаврыг эцэг, эх бүрэн ухамсарлахгүй үлдэх сөрөг талтайн зэрэгцээ гэрлэгч эвлэрэх боломжийг хязгаарладаг.

8. Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх шатанд гэрлэгчдийг эвлэрүүлэх ажиллагааг тухайлсан чиг үүрэг бүхий шүүгч, эвлэрүүлэн зуучлагч, орон тооны бус нэг гишүүнээс бүрдсэн хороо хэрэгжүүлэхээр төсөлд тусгасан байх ба энэ багийн үйл ажиллагааг процессжуулах замаар төслийг сайжруулах шаардлагатай байна. Тодруулбал, энэ баг чиг үүргээ хэрэгжүүлснээр эрхийн акт гарах эсэх, багийн үйл ажиллагааны нууцлал, үе шат, хугацаа, хэрэг хянан шийдвэрлэж буй шүүгч, гэр бүлийн байдлын шинжээчийн багтай харилцах зарчим, журам, эвлэрүүлэх хуралдааны дэг, тэмдэглэл, тэмдэглэлийн нууцлал, төрөл, нотлох баримтаар үнэлэгдэх боломжтой эсэхийг тусгаж, ажиллах журмыг боломжит байдлаар хуульчлан тусгавал зохино.

9. Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2-т Улсын дээд шүүхээс журам батлах, нэхэмжлэл, хариу тайлбарын загвар, маягт гаргахаар заасныг шаардлагагүй гэж үзэж байна. Хялбар хэрэг маргааны хувьд түргэн шуурхай шийдвэрлэх боломжийг нэмэгдүүлэх, нэхэмжлэгч ба хариуцагчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өөрөө шууд оролцох нөхцөлийг бүрдүүлэх үүднээс тус шүүхэд гаргаж байгаа нэхэмжлэл, хариу тайлбар, эрх үүрэг тайлбарлах загвар, маягтыг Улсын дээд шүүхээс баталсан. Харин Гэр бүл, хүүхдийн хэргийн шүүхийн хувьд дагнасан шүүх хэдий ч хялбар хэргийн шүүхээс онцлог ялгаатай тул Улсын дээд шүүхээс нэхэмжлэл, хариу тайлбарын загвар маягтыг батлах гэх мэт байдлаар оролцох шаардлагагүй. Тус шүүхийн ажиллагааг хуульд нарийвчлан тусгах нь зүйтэй бөгөөд нэн шаардлагатай тохиолдолд холбогдох хуулийн зүйл, заалтыг Улсын дээд шүүхээс албан ёсоор тайлбарлах хууль зүйн боломжтой.

10. Төсөлд гэр бүлийн холбогдолтой хэргийг шүүх дангаар шийдвэрлэхээр заасан боловч гэм хорын маргааныг хамтатган шийдвэрлэх тохиолдолд ердийн шүүхийн процессын дагуу бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх, эсхүл дангаар шийдвэрлэх аль нь болох нь ойлгомжгүй байгааг тодруулж гэм хорын маргааныг гэр бүлийн холбогдолтой хэргийг үүсгэх нэхэмжлэлийн шаардлагатай хамтатган гаргасан нь хэргийг гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх үндэслэл болохгүйг дурдвал зохино.

11. Төслийн 24 дүгээр зүйлийн 24.4.3-т заасан хэрэг маргаан нь Гэр бүлийн тухай хуулийн дагуу шүүхийн журмаар цуцлах маргаанд хамаарахгүй тул энэ заалтыг хасах нь зүйтэй.

12. Төсөлд тус хуулийн төслийг дагаж мөрдөх журмыг тусгасан байна. Дагнасан шүүх байгуулахтай зэрэгцэн шүүхийн практикт түгээмэл тохиолдох болсон нэгэн бэрхшээл нь шүүхийг байгуулагдах үед шүүх хооронд хэргийг шилжүүлэхтэй холбоотой харилцаа байдаг. Дагнасан шүүх нь ердийн харьяаллын шүүхэд хянагдаж байсан хэргүүдийг шилжүүлэн авах замаар үйл ажиллагаагаа эхлүүлэх нь зохимжгүй бөгөөд хэргийн оролцогчид хүндрэлтэй байдал үүсгэдэг нь шүүхийн өмнөх практикаас ажиглагдаж байна. Иймд шүүх байгуулагдах үед ердийн харьяаллын шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байсан, эсхүл



хэрэг үүсгүүлэхээр ердийн харьяаллын шүүхэд нэгэнт гаргасан нэхэмжлэлтэй холбоотой ажиллагааг тухайн ердийн харьяаллын шүүх үргэлжлүүлэн хянан шийдвэрлэж дуусгах нь зүйтэй.

13.Хуулийн төсөл хүчин төгөлдөр үйлчилж эхлэх хугацааг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс тогтоохоор хууль санаачлагч томьёолсон нь Шүүх байгуулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх, 5 дугаар зүйлд шүүх байгуулах тухай заалт нь мөн өдөр хүчин төгөлдөр болохоор заасантай холбоотой байна.

Гэр бүл, хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэх шүүгчийг мэргэшүүлэхийн тулд тэдгээрийг томилох шаардлага үүсэх бөгөөд ийнхүү шүүгчдийг томилохын тулд дагнасан шүүх бий болсон байх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Иймд шинэ процессын хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдүүлэхээр заах нь дагнасан шүүхэд ажиллах шүүгчийг мэргэшүүлэх, сургах цаг хугацааны боломжийг харгалзаагүй хэрэг болох тул Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулийг хүчин төгөлдөр мөрдөж эхлэх хугацааг мэргэшүүлэх сургалт зохион байгуулах, шүүхийн захиргааг бүрдүүлэх боломжит хугацаанд нийцүүлэн хойшлуулан тогтоох нь зүйтэй.

14.Хуулийн төслийг дагаж нэмэлт, өөрчлөлт орох зарим хуулийн төсөл, шинээр батлагдах Улсын Их Хурлын тогтоолын төсөлд дараах санал байна. Үүнд:

14.1.Гэр бүлийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд дэх дагнасан шүүхийн хэргийн харьяалалтай холбоотой зүйл, заалтууд 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчлэхээр заасан атлаа тус харилцааг даган өөрчлөлт орж байгаа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хэргийн харьяалалтай холбоотой зохицуулалт нь 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөхөөр заасан нь зөрчилтэй байна.

14.2.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тус хуулийн 6.3 дахь заалтыг төслийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсэгт нийцүүлэн дахин найруулах шаардлагатай. Гэрлэгчид тусдаа амьдарч таваас дээш жил өнгөрсөн тохиолдолд тэдгээрийг эвлэрүүлэхээр урьдчилан шийдвэрлэх ажиллагаа явуулахыг шаардах нь төдийлөн ач холбогдолгүй.

14.3.Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлд "дагнасан шүүгч" гэх нэр томьёог хэрэглэсэн нь оновчтой биш байна. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн дагуу шүүхийг дагнан байгуулах бөгөөд шүүгчийн тухайд "мэргэшсэн шүүгч" гэх нэр томьёог хэрэглэх нь зүйтэй. Түүнчлэн тогтоолын төслийн 2 дугаар зүйлийн 3/, 4/ дүгээр хэсэгт Гэр бүл, хүүхдийн хэргийн шүүхийн шүүгчдийг сургах арга хэмжээг Шүүхийн ерөнхий зөвлөл хэрэгжүүлэхээр заасан нь Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу шүүгч бэлтгэх болон шүүгчийг мэргэшүүлэх сургалтыг Шүүхийн сургалт, судалгаа,



мэдээллийн академи /Шүүхийн академи/ хариуцахаар заасантай нийцэхгүй байна.

15.Хэдийгээр хуулийн төслийг дагалдан Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах санал боловсруулаагүй байх боловч дагнасан шүүхийг Нийслэлийн хэмжээнд анхан шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэхээр байгуулахдаа харьяалах нутаг дэвсгэрийг Нийслэлийн 9 дүүргээр өргөжүүлэх, давж заалдах шатны дагнасан шүүхийн харьяаллыг мөн энэ байдлаар тогтоох, орон нутгийн шүүхэд анхан шатны журмаар шийдвэрлэсэн гэр бүлийн холбогдолтой хэргийг тухайн тойргийн давж заалдах шатны шүүх хянан шийдвэрлэхээр бодлогын арга хэмжээ авах нь зүйтэй.

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААН